ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ
КОМПАНИУДАД

Тодруулга хүргүүлэх тухай

Эрчим хүчний яамнаас зарласан “Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц /Сүхбаатар, Баруун-Урт сум/” төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцохоор сонирхож буй компаниудаас ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

**Асуулт-1:** “...ТӨХ-ийн ТШЗ 19.3-т Тулсан гүйцэтгэгч нь:

*Эрчим хүчний яамнаас олгодог доорхи тусгай зөвшөөрөлтэй байна. Үүнд:*

- ТЗ-5.2 буюу 0.07-4.0 МПа /0.7-40.0 кгх/см$^2$/ даралттай шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ болон түүнээс дээш ангиллын тусгай зөвшөөрөл.

Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог доорхи тусгай зөвшөөрөлтэй байна. Үүнд:

- БА-3.3 Ус хангамж, ариутгах татуургын гол /магистраль/ шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт;
- БА-4.3 Ус хангамж, ариутгах татуургын системийн шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралтын тусгай зөвшөөрөлтэй байна.
- БА-6.4 Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт;

Энэ 2 яамны тусгай зөвшөөрлийг аль нэг нь байвал болох уу? Эсвэл 2-ууланг нь шаардаж байгаа юу?

**Асуулт-2:** “...ТӨХ-ийн ТШЗ 19.3-т Тулсан гүйцэтгэгч нь:

Эрчим хүчний яамнаас олгодог доорхи тусгай зөвшөөрлийг ТЗ-5.2-ыг Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог БА 5.4 тусгай зөвшөөрлөөр дүйцүүлж болох уу?

ТЗ-5.2 буюу 0.07-4.0 МПа /0.7-40.0 кгх/см2/ даралттай шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ болон түүнээс дээш ангиллын тусгай зөвшөөрөл;

БА-5.4 Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт;

2. Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог БА-4.3-ыг БА-6.1 тусгай зөвшөөрлөөр дүйцүүлж болох уу?

БА-4.3 Ус хангамж, ариутгах татуургын системийн шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралт;

БА-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт;

**Хариулт:** ТШЗ 19.3-т “Тендерт оролцогч, түншлэл, туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай бөгөөд тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг Тусгай зөвшөөрлийн цахим мэдээллийн сан

/www.license.energy.gov.mn/, Худалдан авах ажиллагааны цахим системээс шалгах тул тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг тендерийн материалд хавсарган ирүүлэх шаардлагагүй" гэж тус тус заасан.

Дараах тусгай зөвшөөрлүүдийг дүйцүүлэн тооцуулж болно. Үүнд:

| ***Тендерийн баримт бичигт заасан тусгай зөвшөөрөл:*** | **Дүйцүүлэн тооцох тусгай зөвшөөрөл:** |
|---|---|
| *Эрчим хүчний яамнаас олгодог доорхи тусгай зөвшөөрөлтэй байна. Үүнд:*<br>- ТЗ-5.2 буюу 0.07-4.0 МПа /0.7-40.0 кгх/см$^2$/ даралттай шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ болон түүнээс дээш ангиллын тусгай зөвшөөрөл; | *Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог.*<br>- БА-3.4 Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт болон түүнээс дээш төвөгшилтэй ангилалын тусгай зөвшөөрөл; |
| Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог доорхи тусгай зөвшөөрөлтэй байна. Үүнд: | |
| - БА-3.3 Ус хангамж, ариутгах татуургын гол /магистраль/ шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт; | - БА-3.3 Ус хангамж, ариутгах татуургын гол /магистраль/ шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт болон түүнээс дээш төвөгшилтэй ангилалд хамаарах тусгай зөвшөөрлүүд; |
| - БА-4.3 Ус хангамж, ариутгах татуургын системийн шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралтын тусгай зөвшөөрөлтэй байна. | - БА-4.3 Ус хангамж, ариутгах татуургын системийн шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралтын болон түүнээс дээш төвөгшилтэй ангилалд хамаарах тусгай зөвшөөрлүүд;<br>- БА-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт; |